

Чолоолох дайны 75 жилийн түүхэн ойг тохиолдуулан ОХУ-ын Россотрудничество агентлагийн Монгол Улс дахь Толоологчийн газраас санаачлан “Дэлхийн II дайны тогсгол: Манжуурын стратегийн давшилтын ажиллагаанд Монгол Улсын оролцоо” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран Улаанбаатар хот дахь Оросын шинжлэх ухаан, соёлын товд 9 дүгээр сарын 2-ны одор зохион байгуулсан. Уг арга хэмжээнд Монгол, Оросын 20 гаруй эрдэмтэн, судлаачид оролцон илтгэл хэлэлцүүлсэн бөгөөд нийтдээ цэргийн 40 гаруй түүхчдийн илтгэлийг нэгтгэн товхимол болгон хэвлүүлэхээр болсон юм.



Үүнээс гадна Архивын еронхий газар, Үндэсний тов архив, Батлан хамгаалахын тов архив, ТЕГ-ын Тусгай архив, ХХЕГ-ын Улсын хилийн музей, Монгол цэргийн музей, ЗХУ-ын 4 удаагийн баатар, БНМАУ-ын баатар маршал Г.К.Жуковын дурсгалын музейтэй хамтран эх орны дайны эхний сараас эхлэн Монголоос оросын ард түмэнд хүргүүлсэн зургаан удаагийн бэлгийн цуваа, Чолоолох дайнд түүхэн ялалт байгуулахад Монголын цэрэг эрсийн гүйцэтгэсэн гавьяат вйлсийг монхжүүлэх, ирээдүй хойчид дахин сануулах, сурталчлах, хvvхэд, залууст үндэсний бахархалт үзлийг толовшүүлэх зорилгоор “Тусгаар тогтнолын үнэ цэн” үзэсгэлэнг зохион байгуулж, урьд олно нь олон нийтэд огт дэлгэгдэж байгаагүй, түүхийн хосгүй олог, ховор баримт бичиг, гэрэл зураг, дүрс бичлэг бүхий үзмэрийг 9 дүгээр сарын 2-8-нд Оросын шинжлэх ухаан, соёлын товд дэлгэсэн билээ.

2020 оны 9 дүгээр сарын 25-нд дээрх олон улсын эрдэм шинжилгээний хурал болон "Тусгаар тогтнолын үнэ цэн" сэдэвт хамтарсан цогц үзэсгэлэнг зохион байгуулсан байгууллага, ажлын хэсэгт хүндэтгэл үзүүлж, ОХУ-ын Гадаад хэргийн Яамны Жуух бичиг, Холбооны гүйцэтгэх засаглалын Россотрудничество агентлагийн талархлын оргомжлолоор шагнасныг гардуулах ёслолын арга хэмжээ болж, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнг ОХУ-ын Гадаад хэргийн яамны жуух бичгээр, тус хүрээлэнгийн Цэргийн түүх судлалын товийн дарга доктор (Ph.D), хошууч Т.Сүхбаатарыг

Найрамдлын нийгэмлэгүүдийн Монголын эвлэлийн дээд шагнал болох “Найрамдлын Алтан од” одон, Найрамдлын нийгэмлэгийн 70 жилийн ойн медалиар шагнасныг Оросын Холбооны Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Зовлох, Россотрудничество агентлагийн Монгол Улс дахь толоологчийн газрын тэргүүн Базархандаев Амгалан Ринчинович гардуулсан юм.